



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТ ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 27 өдөр

Дугаар A/27

Улаанбаатар хот

“Биеийн тамир, спортын салбарын Улсын”
анхдугаар зөвлөгөөн-2023”-т оролцох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, “Биеийн тамир, спортын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Биеийн тамир, спортын салбарын ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулагдах “Улсын анхдугаар зөвлөгөөн-2023” арга хэмжээнд 2023 оны 08 дугаар сарын 01-нээс 05-ны өдрүүдэд Хэнтий аймагт зохион байгуулагдах тул ажилтан албан хаагчдыг оролцуулсугай.

2.Арга хэмжээний зардалд 6,200,000 (Зургаан сая хоёр зуун мянган) төгрөгийг Нийтийн биеийн тамирын зардлаас гаргахыг нягтлан бодогч (П.Бат-Оюун)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Биеийн тамирын хэлтсийн дарга (Э.Уянга)-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ОТГОНСҮРЭН



Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 47 дугаар тушаалын хавсралт

ТӨСӨВ

2023 оны 07 дугаар сарын 27

Улаанбаатар хот

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН АЖИЛТАН АЛБАН ХААГЧДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ УЛСЫН АНХДУГААР ЗӨВЛӨГӨӨН

| № | Арга хэмжээ, насны ангилал | Хаана болох | Хураамж болон бусад зардал | Нийт дүн |
|---|---|-------------------------|---|------------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Хэнтийн аймагт зохион байгуулагдах Биеийн тамир, спортын салбарын анхдугаар зөвлөгөөн | Хэнтий аймаг Чингис хот | Арга хэмжээний хураамж 1,000,000 Тээврийн зардал 2,500,000 Гэр түрээс 150,000*5 хоног=750,000 Хоол хүнс 13 хүн *30,000=390,000*5 хоног=1,950,000 | 6.200,000 |